



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.28 № 1/24

Зөрчил арилгуулах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2013 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх явцад дараахь зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

ШШГЕГ-ын Шийдвэр гүйцэтгэх газар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны даргын 2012 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд лавлагаа мэдээлэл олгох журам"-ын дагуу аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд гаргаж өгсөн хөрөнгийн лавлагааны хураамжаас 259.6 сая төгрөгийн орлого олж түүгээрээ зарцуулсан байсныг төв аппаратын 2013 оны санхүүгийн тайлан тэнцэлд тусгуулж залруулах бичилт хийлгэсэн болно. Дээрх журмаар аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд лавлагаа мэдээлэл олгох үйлчилгээний хөлсний тарифыг тогтоохдоо холбогдох хууль тогтоомжийг мөрдөөгүй, эрх бүхий албан тушаалтнаар батлуулаагүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1-т "Шүүхийн шийдвэрийг бодитойгоор гүйцэтгэсэн шийдвэр гүйцэтгэгчийг төлбөрийн шаардлагыг хангахаар гаргуулсан мөнгөний болон эд хөрөнгийн үнийн дүнгийн 0.5-10 хүртэлх хувиар урамшуулна", 83.3-т "Энэ хуулийн 83.1-т заасан урамшуулал олгох журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно" гэсний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2013 оны А/181 дүгээр тушаалаар "Шийдвэр гүйцэтгэгчид урамшуулал олгох журам", "Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох журам"-ыг баталсан боловч шийдвэр гүйцэтгэгчид оногдох байгууллагын бараа үйлчилгээний урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэх зорилгоор шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын орлогоос тодорхой хувиар суутган тооцож Голомт банкин дахь дансад хөрөнгө төвлөрүүлэн зарцуулж ирсэн бөгөөд 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3446.2 сая төгрөгийн хуримтлагдсан үлдэгдэлтэй байна. Дээрх журамд шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын орлогоос хуримтлагдсан хөрөнгийг хэрхэн төлөвлөх, зарцуулах, тайлагнах талаар зохицуулаагүй, бусад хууль эрх зүйн акттай нийцэхгүй байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 3.1-т "Татварыг зөвхөн УИХ хуулиар бий болгох, өөрчлөх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох эрхтэй" 5.1-т "Монгол Улсын татвар нь албан татвар, хураамж, төлбөр/цаашид"татвар" гэх/-өөс бүрдэнэ", 5.6-д "...улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгийг хураамж гэнэ" ШШГТХуулийн 9.2-т "Шийдвэр гүйцэтгэгчийн цалингаас бусад үйл ажиллагааны зардлыг энэ хуулийн 83 дугаар зүйлд заасан урамшууллаас санхүүжүүлнэ", 138.4-т "Шийдвэр гүйцэтгэх ажлын онцлогийг тусгасан данс, бүртгэл тайлан тэнцлийн тухай журмыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн хууль



зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно”, “Төсвийн тухай хууль”, “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт”-ын холбогдох заалтуудтай зөрчилдөж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ыг үндэслэн

#### ШААРДАХ НЬ:

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны даргын 2012 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд лавлагаа мэдээлэл олгох журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2013 оны А/181 дүгээр тушаалаар баталсан “Шийдвэр гүйцэтгэгчид урамшуулал олгох журам”, “Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох журам”-ыг холбогдох хууль, эрх зүйн актад нийцүүлэх, урамшууллын орлогоос хуримтлагдсан хөрөнгийг хэрхэн төлөвлөх, зарцуулах, тайлагнах талаар санал боловсруулж холбогдох байгууллагад хандаж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх, шийдвэр гүйцэтгэгчийн урамшууллын орлогоос хуримтлагдсан Голомт банкинд байгаа 3446.2 сая төгрөгийг төрийн санд байршуулан хууль, журмын дагуу зарцуулах арга хэмжээ авч хэрэгжилтийг 2014 оны 10 дугаар сарын 30-ны дотор ирүүлэхийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Д.Ядамдорж, санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Ерөнхий менежер М.Хуягбаатар нарт хариуцуулав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР



Д.ГАНБИЛЭГ